| | үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулах, олон нийтэд үйлчлэх | | мэдээ нэмж бүртгэнэ. | газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ бүртгэх боломжтой болсон. | зах зээлийн үнийн мэдээг Газрын биржийн цахим системд бүртгэсэн байна. | 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр хүлээн авсан. Гүйцэтгэгчээр шалгарсан “Эс ай си эй” ХХК-иас газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн 6696 үнийн мэдээг хүлээн авч шинээр хөгжүүлэлт хийсэн газрын биржийн шинэ цахим системд бүртгэсэн. Газрын биржийн цахим системийн шинэчилсэн хувилбарын хөгжүүлэлт хийгдэж дууссан бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэвтрүүлнэ. | |
| 2.1.7.8 | Газрын биржээр дамжуулан иргэдэд өмчлүүлсэн газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг бүрдүүлэн, систем хөгжүүлэх | Үйл ажиллагаа | Системийн хөгжүүлэлт хийгдсэн эсэх Тийм/Үгүй | - | Тийм | Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас санаачлан газрын биржийн цахим системийг шинэчлэх, хөгжүүлэлт хийх ажлыг нийслэлийн төсвийн хөрөнгөөр зарлаж, гүйцэтгэгчээр “Смарт дата” ХХК шалгарсан бөгөөд тус ажилд хяналт тавьж, бүрэн гүйцэтгүүлэн ГЗБГЗЗЕГ-т хүлээлгэн өгсөн. Газрын биржийн цахим системийг газрын удирдлагын системтэй бүрэн холбож газрын нөөц сан бүрдүүлэх давхарга үүсгэсэн. | 100% |
| 2.1.7.9 | Нийслэлд газар өмчилсөн иргэдийн газарт татвар ногдуулах системийн хөгжүүлэлт хийж гүйцэтгэх | Үйл ажиллагаа | Системийн хөгжүүлэлт хийгдсэн эсэх Тийм/Үгүй | - | Тийм | Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Нийслэлд газар өмчилсөн 207000 иргэний газарт татвар ногдуулах системийн хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгүүлэхээр "Софт Мастер" ХХК-тай 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 97 дугаар гэрээ байгуулсан. Ажлын даалгавар, ажил гүйцэтгэх төлөвлөгөөний дагуу эхлэлийн тайланг 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр, явцын тайланг 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр, эцсийн тайланг 2024 оны 04 дүгээр сарын 29- | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ний өдөр тус тус хүлээн авч, 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн албаны даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж баталсан.<br>ГЗБГЗЗЕГ-т хянуулан акт, дүгнэлт гаргуулахаар 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 01-08/3280 дугаар албан бичгийг хүргүүлж, 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 3/1749 дүгээр албан бичгээр системийн хөгжүүлэлт хийж дууссан бөгөөд ажил шалгасан тухай дүгнэлтийг ирүүлсэн. | |
| 2.1.8 | Газрын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих | Үйл ажиллагаа | Газрын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаа | Газрын кадастрын мэдээллийн санг нэвтрүүлсэн. | Газрын кадастрын мэдээллийн санг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна. | | |
| 2.1.8.1 | Өмнөх онуудад үүсгэсэн нэгж талбарын хувийн хэрэгт хяналт шалгалт хийж, илэрсэн алдаа дутагдалыг арилгах, сайжруулах, нөхөн бүрдүүлэх, цэгцлэх, ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Засвардлагдсан нэгж талбарын хувийн хэргийн тоо | Нэгж талбарын хувийн хэргийн тоо | Нэгж талбарын хувийн хэрэгт холбогдох журмын дагуу хяналт хийгдэж алдаа, дутагдал засварлагдаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Нийслэлийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн нийт 1139 нэгж талбарын хувийн хэрэгт хяналт хийж, бичиглэлийн алдаатай гарсан 36 иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг засварлаж, НЗД-ын 2024 оны А/1084 дүгээр захирамжаар шийдвэрлүүлсэн. | 100% |
| 2.1.8.2 | Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдсэн цахим | Үйл ажиллагаа | Засварлаж сайжруулсан цахим | Системд бүртгэгдсэн өргөдлийн тоо | ГКМС-ийн өргөдлийн цахим хавсралтад хяналт шалгалт хийгдэж | Газрын нэгдмэл сангийн цахим системд алдаатай орсон 298 мэдээллийг засварлаж системд бүртгэн ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | архивын материалд хяналт шалгалт хийж, илэрсэн алдаа дутагдалыг арилгах, сайжруулах, нэгж талбарын хувийн хэргийн бүрдлийн дагуу цахим хавсралтыг баяжуулах арга хэмжээг зохион байгуулах | | хавсралтын тоо | | алдаа дутагдал засварлагдаж, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Баянзүрх-135,<br>Хан-Уул-86,<br>Сонгинохайрхан-57,<br>Баянгол-53,<br>Сүхбаатар-46,<br>Чингэлтэй, Налайх, Багахангай, Багануур-6 иргэн, хуулийн этгээдийн нэгж талбарын хувийн хэргийн бүрдлийн дагуу систем дэх алдааг засварласан. | |
| 2.1.8.3 | Газрын нэгдсэн цахим систем egazar.gov.mn-ийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчилах, танилцуулах арга хэмжээг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Газрын нэгдсэн цахим систем /egazar.gov.mn/ | Цахим системийн хэрэглээ нэмэгдэж иргэд олон нийт Egazar.gov.mn хаягаас газартай холбоотой мэдээ, мэдээлэл авах, цахимаар хүсэлт илгээдэг болсон байна. | Операторын 7777-1285 дугаарын утсаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагад Газрын нэгдсэн цахим систем egazar.gov.mn сайтын талаар дэлгэрэнгүй зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.<br>Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын албаны ажлын байр болон нийслэлийн үйлчилгээний нэгдсэн 3 төвд нийт 22 цахим үйлчилгээний киоск төхөөрөмжийг байршуулан, тэдгээрээр дамжуулан газрын харилцааны үйлчилгээг сурталчлах ажлыг үзүүлж байна. | 100% |
| 2.1.8.4 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлж буй хүсэлтүүдийг цахим системээр дамжуулан хүлээн авч, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Шийдвэрлэгдсэн хүсэлтийн тоо | Газрын кадастрын мэдээллийн санд нийт бүртгэсэн өргөдөл | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлж буй хүсэлтүүдийг цахим системээр дамжуулан хүлээн авч, шийдвэрлэх ажлыг зохион байгуулсан байна. | Газрын тухай хуульд 2023 онд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших тухай хүсэлтийг цахим систем болон төрийн үйлчилгээний нэгдсэн цахим системээр дамжуулан гаргадаг болсон бөгөөд өргөдлийн бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн дараалын дагуу тухайн жилийн газар зохион байгуулалтын | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөгөөнд туссан нэгж талбараас сонгож эзэмшүүлдэг болсон. Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын алба 2024 оны жилийн эцсийн байдлаар 2941 цахим өргөдлийг хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байна. | |
| 2.1.8.6 | Киоск төхөөрөмжийг хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийтэд нэг цэгээс түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэх | Орон нутгийн төсөв | Шинээр нэвтрүүлсэн төхөөрөмжийн тоо | Нийслэлийн хэмжээнд 2022-2023 оны хооронд нийт 14 төхөөрөмжийг нэвтрүүлсэн. | Киоски төхөөрөмжийг хүртээмж нэмэгдэж газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийт нэг цэгээс түргэн шуурхай авах боломж бүрдсэн байна. | Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын албаны ажлын байр болон нийслэлийн үйлчилгээний нэгдсэн 3 төвд нийт 8 цахим үйлчилгээний киоск төхөөрөмжийг нэмж байршуулан, тэдгээрээр дамжуулан газрын харилцааны үйлчилгээг сурталчлах ажлыг үзүүлж байна. | 100% |
| 2.1.8.9 | ГКМС-д бүртгэгдсэн орон нутгийн тусгай хэрэгцээний газрын давхаргад хяналт шалгалт хийж буруу, зөрүүтэй бүртгэгдсэн мэдээллийг эрх бүхий этгээдийн шийдвэрт үндэслэн засварлах, сайжруулах, шинээр ОНТХ-нд авсан газрыг бүртгэж баталгаажуулах | Үйл ажиллагаа | Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрын тоо | - | ***Жилийн эцэст:*** Нийслэлийн хэмжээнд Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан эрх бүхий этгээдийн шийдвэрийн судалгааг гаргаж, ГКМС-д бүртгэгдсэн мэдээлэлд нэг бүрчлэн хяналт хийж, илэрсэн алдаа дутагдлыг засварласан байна. Шинээр авсан газрыг кадастрын нэгдсэн системд бүртгэж, | Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 3 байршлын 986.2 га газрыг улсын болон Орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, батлагдсан хил заагийг Газрын кадастрын мэдээллийн сангийн “Орон нутгийн тусгай хэрэгцээний газар” давхаргад бүртгэж ажилласан.<br>Үүнд:<br>1.НИТХ-ын 2024 оны 70 дугаар тогтоолоор Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, С.Зоригийн агсаны хөшөө орчмын 0.08 га талбайг, НИТХ-ын 2024 оны 71 дүгээр тогтоолоор Баянзүрх дүүргийн 11, 26 дугаар хорооны нутаг дэвсгэр 973.3 га талбай бүхий газрыг нийтийн эдэлбэр газрын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баталгаажуулсан байна. | зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд тус тус авсан.<br>2.НИТХ-ын 2024 оны 49 дүгээр тогтоолоор Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт 12.8 га талбай бүхий газрыг нийтийн эдэлбэр газрын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авах саналыг дэмжсэн бөгөөд Засгийн Газрын 2024 оны 249 дүгээр тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан.<br>3.Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан Баянзүрх ДИТХ-ын тогтооолоор 1 байршилд 6019 га газар, Налайх ДИТХ-ын тогтоолоор 9 байршилд 5921 га газар буюу нийт 10 байршлын 11940 га газрыг Газрын кадастрын мэдээллийн сангийн ‘’Орон нутгийн тусгай хэрэгцээний газар’’ давхаргад бүртгэсэн. | |
| 2.1.8.10 | Газрын кадастрын цахим системийн өгөгдөл, мэдээлэлд хяналт хийж, алдаатай, зөрүүтэй оруулсан мэдээллийг засварлах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн цахим систем | Газрын нэгдмэл сангийн цахим систем | Газрын нэгдмэл сангийн цахим системийн мэдээлэл засварлагдсан байна. | 2019 оны А/75 дугаар тушаалаар батлагдсан “Мэдээллийн санд хяналт тавих ажлын хэсэг”-ийн хурлаар 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 17 удаагийн хурлаар 520 иргэн, хуулийн этгээдийн асуудлыг хэлэлцүүлж, 102 иргэн, хуулийн этгээдэд боломжгүй тухай хариуг албан бичгээр хүргүүлж, 418 иргэн, хуулийн этгээдийн зөрүүтэй оруулсан мэдээллийг газрын кадастрын мэдээллийн санд завсарлан баталгаажуулсан. | 100% |
| 2.1.8.11 | Газрын кадастрын мэдээллийн сангийн зөрчилтэй нэгж талбарын давхаргад хяналт | Үйл ажиллагаа | Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажсан | Газрын кадастрын мэдээллийн систем | Зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилган Газрын кадастрын мэдээллийн | Газрын кадастрын мэдээллийн сангийн зөрчилтэй нэгж талбарын давхаргад хяналт хийж, зөрчилтэй байсан 138 нэгж талбарын мэдээллийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хийж зөрчил арилсан мэдээллийг шинэчлэх, одоо байгаа болон шинээр илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах | | нэгж талбарын тоо | | системд баталгаажуулсан байна. | засварлаж үндсэн давхаргад бүртгэсэн. Үүнд:<br>-Баянзүрх-14,<br>-Хан-Уул-40,<br>-Сонгинохайрхан-57,<br>-Чингэлтэй-1,<br>-Баянгол-17,<br>-Сүхбаатар-9 нэгж талбарын мэдээллийг тус тус засварлан Газрын кадастрын мэдээллийн санд оруулсан. | |
| 2.1.9 | Салбарын хэмжээнд сүлжээ, техник, програм хангамж, системийн хэвийн, аюулгүй, найдвартай үйл ажиллагааг хангах | Үйл ажиллагаа, урсгал төсөв, хөрөнгө оруулалт | Сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, Техник, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа | Байгууллагын дотоод сүлжээ домэйн удирдлагын системд холбогдсон. 21 аймаг тоон мэдээлэл дамжуулах байнгын холболтод холбогдсон. Мэдээллийн аюулгүй байдлын газрын Төрийн хамгаалагдсан нэгдсэн сүлжээнд холбогдсон. Байгууллага, нийслэл, 21 аймаг, 345 цэг /сум, суурин, GNSS БАС/ интернэтийн | Сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, Техник, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажилласан байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сүлжээнд холбогдсон. | | | |
| 2.1.9.1 | Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний аюулгүй, хэвийн ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | Байгууллагын сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангасан байдал | - | Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний аюулгүй, хэвийн ажиллагааг хангасан байна. | Байгууллагын интернет, тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт /VPN/ болон дотоод сүлжээний хэвийн аюулгүй байдлыг нэгдсэн удирдлагын систем болон Watchguard галт хана ашиглан хэвийн ажиллагааг ханган түүнд хяналт тавин ажиллаж байна.<br>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд А блокоос Б блокруу нүүсэнтэй холбоотой байгууллагын сүлжээг дахин зохион байгуулах шаардлагатай болсон тул төв Хангарди ордонд байрлах Mikrotik CCR1016, Firebox T70 төхөөрөмжүүдийг дахин загварчилж тохируулсан. Тус ажлын дагуу Нийслэлийн 6 дүүргийн 8 газар зохион байгуулалтын албаны Mikrotik RB45 төхөөрөмжийг дахин тохируулж хэвийн ажиллагаанд оруууллаа.<br>Шилэн кабель шинээр орсонтой холбогдуулан Mikrotik RB1100 төхөөрөмж шинээр байршуулж холболтыг идэвхжүүлэв. Сүлжээний ерөнхий зохион байгуулалтыг Mikrotik CCR1016 төхөөрөмж дээр болон төв Хангарди ордоны Дата төвтэй холбох тохиргоо, албан хаагчдын дотоод сүлжээний физик зохион байгуулалтыг тус тус хийж хэвийн ажиллагаанд оруулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.9.2 | Байгууллагад хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмж, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | Техник, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангасан байдал | Асуудал гарсан тухай бүрд техник засвар үйлчилгээг цаг алдалгүй хийж хэвийн ажиллагааг хангасан. Байгууллагад хэрэглэгдэж буй бусад техник, тоног төхөөрөмж, хэрэглээний програм хангамжийн хэвийн, ажиллагааг хангаж ажилласан. | - Байгууллагад хэрэглэгдэж буй хэрэглээний програм хангамж, техник, тоног төхөөрөмжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа хангагдсан байна. | Засварлах шаардлагатай 121 компьютерыг нэгдсэн удирдлагын системийн шинэчилсэн стандартын дагуу засварлан тоног төхөөрөмж болон хэрэглээний программ хангамжийн хэвийн ажиллагааг хангасан.<br>Сэлбэ дэд төвд байршиж ажиллах болсон нийт албан хаагчийн ашиглах шилэн забелийн холболтыг Юнивишн ХХК-тай хамтран хайгуул хийн тохирох худгаас шилэн кабель татан Mikrotik RB45, ONT шилэн кабелийн төхөөрөмжүүдийг байршуулан 100mbs хурдаар сүлжээний зохион байгуулалтыг хийж хэвийн ажиллагаанд оруулаа.<br>Нийслэлийн 9 дүүргийн 11 газар зохион байгуулалтын албанд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, Hikvision NVR төхөөрөмжийг суулгаж нэгдсэн хяналтад оруулаад байна. Ажиллагаагүй болсон хяналтын камеруудыг Hikvision Cube, Hikvision Dome төхөөрөмжөөр бүрэн шинэчилж дууссан.<br>Мөн файл хадгалах серверийн үйлдлийн системийн доголдлын улмаас байгууллагын файлын сан устах аюулд хүрсэн тул үйлдлийн системийг дахин суулгаж, байгууллагын нэгдсэн сүлжээний удирдлагыг шинэчилсэн. | 100% |
| 2.1.10 | Байгууллагын болон салбарын үйл ажиллагаанд шаардлагатай веб хуудас, программ | Үйл ажиллагаа, урсгал төсөв | 3 цахим системийн нэмэлт хөгжүүлэлт | 8 веб хуудас хэрэглээнд гаргасан. | 3 цахим системийн нэмэлт хөгжүүлэлт хийж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангамжийн хөгжүүлэлтийг хийх хэрэглээнд нэвтрүүлэх | | | | | | |
| 2.1.10.1 | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем /Геопортал/-ийн дэд санг стандартын дагуу бүрдүүлэх | Үйл ажиллагаа | Дэд сан бүрээр бүрдүүлсэн өгөгдлийн тоо | 2023 онд Геопорталд дэд сан бүрээр өгөгдөл бүрдүүлсэн. | Хамаарах нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрдүүлсэн байрлалд суурилсан мэдээллийг орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем (Геопортал)-д 18 дэд сангийн стандартын дагуу баяжуулж, бүрдүүлсэн байна. | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем (Геопортал)-д 18 дэд сангаас өөрийн байгууллагын эрхлэх ажлын хүрээнд 2 дэд санд стандартын дагуу өгөгдөл бүрдүүлэн ажилласан.<br>Үүнд:<br>- Геодезийн цэг, тэмдэгт-539 цэг, тэмдэгт<br>- Газар зүйн нэр- 531 нэр (шугаман мэдээлэл), 646 нэр (цэгэн мэдээлэл) нийт 1177 нэр | 100% |
| 2.1.12 | Салбарын архивын баримтаар хэрэглэгчдэд үйлчлэх | Үйл ажиллагаа | Цаасан болон цахим баримтын үйлчилгээ | 1685 хадгаламжийн нэгжийн баримтаар үйлчилгээ үзүүлсэн. | Цаасан болон цахим баримтаар үйлчилгээ үзүүлсэн байна. | | |
| 2.1.12.1 | Архивын баримтаар байгууллага, иргэдэд цахим үйлчилгээ үзүүлэх, лавлагаа мэдээлэл олгох | Үйл ажиллагаа | Ирүүлсэн хүсэлтийн дагуу үзүүлсэн үйлчилгээний тоо, төрөл | 2023 онд архивын баримтаар 1746 хадгаламжийн нэгжийн баримтаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэн болон байгууллагын дотоодын үйл ажиллагаанд | Ирүүлсэн хүсэлтийн дагуу цаасан болон цахим баримтаар үйлчилгээ үзүүлсэн байна. | 2024 оны байдлаар нийт 11789 иргэн, хуулийн этгээдэд архивын баримтын лавлагаа, хуулбар олгон, архивын үйлчилгээ үзүүлсэн.<br>Албан хаагчид болон ГЗБГЗЕГ-ийн хяналт шалгалтын багт 5200 баримт түр ашиглуулсан.<br>Төрийн сангийн 100200329001 тоот дансанд архивын лавлагааны хураамж 10,9 сая төгрөг төвлөрүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | үйлчилгээ үзүүлсэн. | | | |
| 2.1.13 | Төрийн архивын стандарт орчныг сайжруулах | Үйл ажиллагаа | Төрийн архивын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа | - | Төрийн архивын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна. | | |
| 2.1.13.1 | Архивын хадгаламжийн санг зориулалтын шүүгээ, тавиур, техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах талаар санал тавьж шийдвэрлүүлэх | Үйл ажиллагаа | Саналын тоо | Жил бүр архивын стандарт орчныг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулдаг. | **Эхний хагас жилд:** Архивын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай стандарт орчныг бүрдүүлэх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглох зардлын тооцоо гарган удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. **Жилийн эцэст:** Шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авсан байна. | Архивын баримтын хадгалалтын горимыг Хууль зүй дотоод хэргийн Сайдын 2021 оны А/222 тушаалаар баталсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”, нийслэлийн Засаг даргын 2015 оны А/172 захирамжид нийцүүлэн ажиллаж байна.<br><br>Архивын шаардлагатай тоног төхөөрөмж авах тендерийн ажлын даалгавар болон үнэлгээний хороог 2024 оны А/72 дугаар тушаалаар байгуулж, 2024.07.09-ний өдөр тендер зарлаж сонгон шалгаруулалтаар шалгарсан компанитай гэрээ байгуулж, тендер сонгон шалгаруулалтаар 15, шууд гэрээгээр 8 нийт 23 архивын нягтаршуулсан шүүгээ авч, архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулсан.<br><br>+++ | 100% |
| 2.1.14 | Геодезийн хэмжилтийн багаж баталгаажуулалтын лабораторийн үйл ажиллагааг сайжруулах | Үйл ажиллагаа | Баталгаажуулсан багажны тоо | 2022 онд улсын хэмжээнд 2325 багаж баталгаажуулсан. | 2023 онд улсын хэмжээнд 1540 багажийг баталгаажуулсан байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.14.1 | Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хэрэглэж буй геодезийн хэмжлийн багажийг баталгаажуулах | Үйл ажиллагаа | Баталгаажуулсан багажны тоо | - | Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хэрэглэж буй геодезийн хэмжлийн багажийг хугацаанд нь баталгаажуулсан байна. | 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр байгууллагын үйл ажиллагаанд ашигладаг trimble R10 2 долгионы GPS-ийн хяналтын хэмжилтийг Төв аймгийн Номтын аманд байрлах ГЗБГЗЗГ-ын хэмжил зүйн жишилтийн полгионд хийж гүйцэтгэн, үр дүнг 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Геодезийн хэмжил зүйн лабораторт хүргүүлж, 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 0031181 дугаартай гэрчилгээ авч баталгаажуулсан. | 100% |

**ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 3.1<br>Улсын хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалт хийнэ.** | | | | | | | |
| 3.1.1 | Газар зүйн нэрийн тодруулалт | Улсын болон орон нутгийн төсөв | Нэрийн тодруулалт хийх аймаг, сумын тоо | 2023 онд 11 аймгийн 35 сум, нийслэлийн 1 дүүрэг газар зүйн нэрийн тодруулалтын ажил хийсэн. | Нэрийн тодруулалт хийх ажлын төсөв батлагдсан аймаг, сумын газар зүйн нэрийн тодруулалт хийгдэж, мэдээллийн сан байгуулна. | | |
| 3.1.1.2 | Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах | Урсгал төсөв | 2 хурал | 2023 оны Газар зүйн нэрийн зөвлөлийн төлөвлөгөөг боловсруул | **Эхний хагас жилд:** Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж | Нийт 9 дүүргийн газар зохион байгуулалтын алба нь газар зүйн нэрийн дэд зөвлөлийг дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулсан бөгөөд Сонгинохайрхан, Хан-Уул, Багахангай дүүргийн Газар зохион | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ж, батлуулсан. 4 удаа газар зүйн нэрийн зөвлөлийн хурлыг зохион байгуулсан. | батлуулах, 1 удаагийн хурлыг зохион байгуулж, хурлын тэмдэглэлийг баталгаажуулан ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. **Жилийн эцэст:** Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж, хурлын тэмдэглэлийг баталгаажуулан ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | байгуулалтын албад 2024 оны газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг хийж тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэхэд бэлэн болсон.<br>Сүхбаатар дүүргийн Газар зохион байгуулалтын алба газар зүйн нэрийн дэд зөвлөлийг хуралдуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.<br>Баянгол дүүргийн Газар зохион байгуулалтын алба газар зүйн нэрийн дэд зөвлөлийг хуралдуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар хүлээгдэж байна.<br>Баянзүрх, Багануур, Чингэлтэй, Налайх дүүргийн Газар зохион байгуулалтын албад 2025 оны төсөвт газар зүйн нэрийн тодруулалтын ажлын төсвийг тусгуулах санал хүргүүлсэн.<br>НЗД-ын 2023 оны “Газар зүйн нэрийн салбар зөвлөл байгуулах тухай” А/1403 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тул НЗД-ын захирамжийн төслийг шинээр боловсруулан 2024 оны 01-09/8377 дугаар албан бичгээр НЗДТГ- хүргүүлсэн. | |
| 3.1.3 | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах | Үйл ажиллагаа | Бэлчээрийн фото мониторингийн 5166 цэг | 2022 онд Бэлчээрийн фото мониторингийн 5166 цэгт бэлчээрийн фотомониторингийн ажлыг зохион байгуулсан. | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн 320 сумын хэмжээнд бэлчээрийн газрын 5166 мониторингийн цэгт хийсэн байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.3.1 | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах | Үйл ажиллагаа | Мониторингийн цэгийн тоо | 2023 онд нийслэлийн 6 дүүргийн бэлчээрийн газарт фото мониторингийн ажлыг зохион байгуулагдсан. | **Жилийн эцэст:**<br>2024 оны бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулан нэгтгэж, холбогдох зөвлөмжийг гаргаж, газрын мониторингийн цахим системд бүрэн оруулж, тайланг 10 сарын 01-ны дотор хүргүүлсэн байна. | ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/105 дугаар тушаалаар батлагдсан “Бэлчээрийн газрын фото мониторингийн аргаар үнэлэх журам”-д заасны дагуу Нийслэлийн хэмжээнд 2024 оны “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх” ажлыг гүйцэтгэж үр дүнд гарсан биомассыг Зайнаас тандан судлалын арга ашиглан гаргаж харьцуулан үзэж, дүн шинжилгээ хийсэн тайланг 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр ГЗБГЗЗЕГ-ын ГМХ-т хүргүүлсэн.<br><br>Нийслэлийн фото мониторингийн цэг төлөөлөх талбайг нарийвчлан зураглаж, газрын мониторингийн цахим системд оруулах ажлын хүрээнд ГЗБГЗЗЕГ-ын дарга, НЗД-ын хамтарсан 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн АД/2024-16 дугаар ажлын даалгавар батлагдсан. Тус албаны даргын 2024 оны А/35 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдаж, тендерт “Эрхэт инноваци” ХХК шалгарсан 2024 оны 142/24 тоот албан бичгээр эцсийн тайланг тус албанд ирүүлсэн бөгөөд 2024 оны 01-07/8342 дугаар албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т захиалагчийн хяналтад дүгнэлт гаргуулахаар хүргүүлсэн. | 100% |
| 3.1.3.3 | Бэлчээрийн фото мониторингийн багаж хэрэгслийг шинэчлэх судалгааг гаргах, мөн багаж | Үйл ажиллагаа | Багаж, хэрэгслийн тоо | - | **Эхний хагас жилд:**<br>Бэлчээрийн фото мониторингийн багаж хэрэгслийг шинэчлэх судалгааг гаргаж | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх хээрийн судалгааны ажилд шаардагдах 16 төрлийн багаж хэрэгсэл бүрэн эсэх судалгааг дүүрэг тус бүрээр гаргаж, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах | | | | ГЗБГЗЗЕГ-т хүргүүлж, багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулсан байна. | шаардлагатай багаж хэрэгсийн бүрдлийг хангуулан тайланг ГЗБГЗЗЕГ-т 2024 оны 01-07/5611 дүгээр албан бичгээр хүргүүлсэн | |
| 3.1.4 | Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах | Үйл ажиллагаа | Төлөвлөгөөт болон захиалгат хянан баталгаа хийгдсэн тоо | Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийсэн ажлын тайлан мэдээ | Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийх ажлыг зохион байгуулахад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж, хянан баталгааны үр дүнг мониторингийн цахим системд оруулсан байна. | | |
| 3.1.4.1 | Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийж, цахимаар болон хэвлэмэл байдлаар ирүүлсэн тайлан, дүгнэлтийг хянаж, баталгаажуулах | Үйл ажиллагаа | Захиалгат хянан баталгаа хийж, баталгаажсан тайлан, дүгнэлтийн тоо | 2023 онд нийт 8736 тайлан, дүгнэлт баталгаажуулсан. | **Эхний хагас жилд:** Цахим системээр хянан баталгааны тайлан, дүгнэлтийг баталгаажуулахад гарч буй алдаа, зөрчлийг засварлаж, тайлангийн үр дүнг сайжруулсан байна. Цахимаар илгээсэн хянан баталгааны тайлан, дүгнэлтийг хянаж баталгаажуулсан байна. **Жилийн эцэст:** Цахимаар илгээсэн хянан баталгааны тайлан, дүгнэлтийг хянаж баталгаажуулсан байна. | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн дэд систем болох газрын мониторингийн цахим системээр ирүүлсэн 14586 захиалгат хянан баталгааны дүгнэлтийг хянаж баталгаажуулж, нэгдсэн тайланг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт 2024 01-07/7493 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.4.2 | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлыг зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Орон нутгийн төсвөөр хийгдсэн ажлын тоо | - | **Эхний хагас жилд:** Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлын даалгаврыг боловсруулж, агентлагаас санал авч батлуулсан байна. **Жилийн эцэст:** Газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлын эцсийн шатны тайланг хянаж, ажлын үр дүн, тоон мэдээллийг гүйцэтгэгч байгууллагаар газрын мониторингийн цахим системд оруулахад хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна. | Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зориулалттай 207 га газарт төлөвлөгөөт хянан баталгаа хийхээр дүүргийн төсөвт 84,0 сая төгрөг тусгагдсаны дагуу ажлын даалгаврыг боловсруулан ГЗБГЗЗЕГ-ын санал авч 2024 оны 01-07/4214 дүгээр албан бичгээр БГДГЗБА-нд чиглэл хүргүүлсэн. Уг ажилтай холбогдуулан БГДГЗБА-аас 2024 оны 05/1006 дугаар албан бичгээр дүүргийн төсвийн асуудлаар хүлээгдэж байгаа талаар тайлбар ирүүлсэн.<br>Хан-Уул дүүргийн 9, 16 дугаар хороо (нисэх орчимд) төлөвлөгөөт хянан баталгаа хийх 12,6 сая төгрөгийг дүүргийн төсөвт тусгагдсаны дагуу ажлын даалгаврыг боловсруулан ГЗБГЗЗЕГ-ын санал авч 2024 оны 01-07/6345 дугаар албан бичгээр ХУДГЗБА-д чиглэл хүргүүлсэн.<br>Уг ажлыг гүйцэтгүүлэхээр www.tender.gov.mn- д зарласан боловч тендерт санал ирүүлээгүй.<br>2025 онд дүүргүүдийн нутаг дэвсгэрт төлөвлөгөөт хянан баталгаа хийгдэх шаардлагатай хөрөнгийг орон нутгийн төсөвт тусгуулж, хэрэгжүүлэх ажиллах тухай чиглэлийг дүүргүүдийн Засаг дарга нар, Газар зохион байгуулалтын албадад 2024 оны 01-07/8339 дүгээр албан албан бичгээр хүргүүлсэн. | 100% |
| 3.1.5 | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулсан | 21 аймгийн 330 сумын 2022 оны сумын тухайн жилийн газар зохион | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүрэн оруулж, хэрэгжилтэд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төслийн тоо | байгуулалтын төлөвлөгөө боловсруулсан байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. | системээр хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулсан байна. | | |
| 3.1.5.1 | Нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнах | Үйл ажиллагаа | Нийслэлийн хэмжээнд | Нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө хэрэгжилт болон газар олголтын байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгаж тайлагнасан байна.<br>Нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг 12 дугаар сарын 20-ны дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Нийслэлийн 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг НИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 125 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Мөн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 86, 130 дугаар тогтоолоор нийслэлийн 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэмэлт, өөрчлөлтийг батлуулж, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд төлөвлөгөөг баталгаажуулж бүртгэсэн. 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 2 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, төлөвлөгөөний биелэлтийг 91.3 буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнүүлсэн. | 91,3% |
| 3.1.5.2 | Дүүргийн газар зохион байгуулагчдыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | 2 сургалт | 2 сургалт | Цахим болон танхимаар сургалт зохион байгуулсан байна.<br>Сургалт зохион байгуулсан тайлан | Газар зохион байгуулалт, төлөвлөлттэй холбоотой ирүүлсэн чиглэлийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр ГЗБГЗЗЕГ-ын Газар зохион байгуулалтын хэлтсийн Ахлах мэргэжилтэн Г.Гэрэлтуяа, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээг тухай бүр тайлагнасан байна. | цахим системийн үйл ажиллагаа хяналт шалгалттай холбоотой асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Шинэтөрболд нартай хамтарсан уулзалт зохион байгуулж, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд нэвтрэх эрх, хяналт шалгалт хийхэд тулгарч буй зарим асуудлын талаар сургалтад хамрагдсан.<br>2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр 9 дүүргийн 11 ГЗБА-ны Газар зохион байгуулалт хариуцсан 14 албан хаагчдад Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах арга зүй, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийн талаарх сургалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр албаны мэдээллийн цагаар “Газрын кадастрын мэдээллийн сангийн аюулгүй байдал” сэдвээр нийт 198 албан хаагчдад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч, гарын авлагаар хангаж, сургалт зохион байгуулж ажилласан. | |
| 3.1.5.3 | Монгол улсын иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтын саналыг 2024 оны 3 дугаар улиралд багтаан нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар | Үйл ажиллагаа | 2025 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын санал | Жил бүр хийгддэг. | **Жилийн эцэст:**<br>Иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг сум тус бүрээр гаргаж, нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлж, 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Дүүргийн Газар зохион байгуулалтын албадаас сар бүрийн 25-ны өдөр 2025 онд эзэмшиж буй газраа өмчлөх хүсэлтэй иргэдийн мэдээллийг авч нэгтгэн ажиллаж байна.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар 1689 иргэн саналыг ирүүлснийг 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тусгасан бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 2 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах | | | | | дугаар чуулганаар хэлэлцүүлж батлуулсан. | |
| 3.1.5.4 | 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулах ажлыг зохион байгуулж, тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг гарган хүргүүлэх | Үйл ажиллагаа | 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл | - | **Жилийн эцэст:** Нийслэл, дүүргийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг батлах эрх бүхий байгууллагад хүргүүлэх, тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг батлах тухай тогтоолын төсөлд тусгах саналаа 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд Улаанбаатар хотоос сонгогдсон Улсын Их Хурлын 24 гишүүн, 8 яам, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 45 төлөөлөгч, 9 дүүргийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Засаг даргын 11 хэрэгжүүлэгч агентлаг, 6 НӨААТҮГ, 2 төслийн нэгж болон иргэд, олон нийтийн цахимаар гаргасан 1689 нийт 2500 орчим санал ирүүлснийг Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1248 дугаар захирамжаар байгуулагдсан нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгээр хэлэлцүүлэн төлөвлөгөөний төслийг боловсруулан, ГЗБГЗЗЕГ-нд хянуулж 1/3357 дугаар албан бичгээр тус газраас дүгнэлт ирүүлсэн.<br>Нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 4 бүлгийн 27 дэд бүлэгт хамаарах 631 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 2 дугаар чуулганаар хэлэлцүүлж батлуулсан. | 90% |
| 3.1.6 | Улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхлэх | Үйл ажиллагаа | Газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан Засгийн газрын | Засгийн газрын тогтоолын дагуу улсын тусгай хэрэгцээнд | Улсын тусгай хэрэгцээнд газрыг авах, гаргах асуудлын хэрэгцээ, шаардлагыг судлах, холбогдох судалгаа | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тогтоол | авсан 3 газрын гэрээ гэрчилгээг олгох ажлын зохион байгуулсан. | хийж, дүгнэлт гаргаж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлсэн байна. | | |
| 3.1.6.1 | Хил хамгаалах ерөнхий газрын харьяа анги, салбаруудын тусгай хэрэгцээний газрын хил заагийг өөрчлөх, улсын тусгай хэрэгцээнд шинээр авах, хэсэгчлэн болон бүхэлд нь улсын тусгай хэрэгцээний газраас гаргах саналыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, тогтоолын эх хувийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | Нийслэлийн ИТХ-ын тогтоол | УИХ-ын 2010 оны мн/27 дугаар тогтоол | **Эхний хагас жилд:** Хил хамгаалах ерөнхий газрын харьяа анги, салбаруудын тусгай хэрэгцээний газрын хил заагийг өөрчлөх, улсын тусгай хэрэгцээнд шинээр авах, хэсэгчлэн болон бүхэлд нь улсын тусгай хэрэгцээний газраас гаргах саналыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, тогтоолын эх хувийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Дээд шатны байгууллагаас Хил хамгаалах ерөнхий газрын харьяа анги, салбаруудын тусгай хэрэгцээний газрын хил заагийг өөрчлөх, улсын тусгай хэрэгцээнд шинээр авах, хэсэгчлэн болон бүхэлд нь улсын тусгай хэрэгцээний газраас гаргах санал ирээгүй байна.<br><br>Мөн тус арга хэмжээтэй холбогдуулан нийслэлийн нутаг дэвсгэрт хамаарах тус газрын харьяа анги, салбаруудаас дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байршил байгаа эсэх талаарх холбогдох мэдээллийг авахаар Хил хамгаалах ерөнхий газарт 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 01-04/7203 дугаар албан бичгийг хүргүүлсэн. | - |
| 3.1.7 | Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэл, газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хянах | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн 2021 оны улсын нэгдсэн тайлан | Газрын нэгдмэл сангийн 2020 оны улсын нэгдсэн тайлан Засгийн газарт танилцуулагдсан. | Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэлийн үйл ажиллагааг эрхэлж газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөн бүртгэгдсэн байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.7.1 | Газрын нэгдмэл сангийн 2024 оны тайланг дүүргүүдээс авч нэгтгэн, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн 2024 оны тайлан | Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | **Жилийн эцэст:** Газрын нэгдмэл сангийн 2024 оны тайланг хуульд заасан хугацаанд хүлээн авч нэгтгэн, дараа оны 01 сарын 15-ны өдрийн дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын нэгдмэл сангийн тайлан гаргах журам”, Засгийн газрын 2003 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан ГТ1-9 маягтуудын дагуу нэгтгэн, 2023 оны Газрын нэгдмэл сангийн тайланг нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01/287 дугаар албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлсэн.<br>2024 оны Газрын нэгдмэл сангийн тайланг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон ГТ1-9 маягтуудын дагуу нэгтгэн 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ. | 100% |
| 3.1.7.2 | Газрын нэгдмэл сангийн тайланг Газрын нэгдмэл сангийн мэдээллийн системээс гаргах ажлын хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн тайлан | - | **Жилийн эцэст:** Газрын нэгдмэл сангийн тайланг Газрын нэгдмэл сангийн мэдээллийн системээс гаргасан байна. | Газрын нэгдмэл сангийн тайланг нэгтгэн хүргүүлэх хугацаа болоогүй бөгөөд тайлан гаргахтай холбогдуулан ГЗБГЗЗЕГ-аас чиглэл, зөвлөмж авахаар 2024 оны 01-05/8198 дугаар албан бичгийг хүргүүлсэн. | 100% |
| 3.1.8 | Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл, хөтөлбөрийн хүрээнд газар чөлөөлөх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна. | 150,000,0 Улс, нийслэлийн төсөв | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар | 100 | 100 | | |
| 3.1.8.1 | Бүтээн байгуулалтын | 150,000.0 | Нэгж талбар, тоо | 1084 | 1500 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Нийслэлийн 2024 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлын нөлөөлөлд өртсөн газрыг чөлөөлөх. | Нийслэлийн төсөв | | | | оны төсөв батлах тухай" 122 дугаар тогтоолоор улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний газар чөлөөлөлт, нөхөх олговорт 150 тэрбум, 2024 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан нийслэлийн төсвийн тодотголд тус хөрөнгийг нэмэгдүүлэн 294,4 тэрбум төгрөг болгон баталсан. Мөн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 105 дугаар тогтоолоор газар чөлөөлөх нөхөх олговрын хөрөнгийг 406,71 тэрбум төгрөгөөр баталсан.<br>Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Нөхөх олговор олгох тухай" 136 удаагийн захирамжаар 1995 нэгж талбарын 885,838 м2 газрыг чөлөөлж, 386 тэрбум 41 сая төгрөгийн нөхөх олговрыг бүтээн байгуулалтын ажлын нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдэд олгосон. Нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөлд 103 нэгж талбарын 46,365 м2 газарт 19,62 тэрбум төгрөг олгохоор хянагдаж байна. | |
| 3.1.8.2 | Дэд төвүүдийн газар чөлөөлөлтийг үргэлжлүүлэх | Үйл ажиллагаа | Нэгж талбар, тоо | - | 5 | Дэд төвүүдийн газар чөлөөлөлтийн хүрээнд Сэлбэ дэд төвийн барилгажуулах ажлын газар чөлөөлөлт хийгдэж байна.<br>Сэлбэ дэд төвийн 158.0 га газарт нийт 2206 нэгж талбар өртсөн бөгөөд 1682 нэгж талбар буюу 76.2 хувиас нийгэм эдийн засгийн судалгаа болон санал асуулга авсан бөгөөд 1596 нэгж талбар буюу судалгаанд хамрагдсан иргэдийн 96.5 хувь дэмжсэн 2.3 хувь буюу 51 нэгж талбар татгалзсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хөрөнгийн үнэлгээний хэмжилт 1605 нэгж талбарт 72.7 хувьд хийгдсэн.<br>НЗД-ын 27 удаагийн захирамжаар 1575 нэгж талбарт 295.2 тэрбум төгрөгийг олгохоор шийдвэрлэгдсэн бөгөөд 2024 оны 12 дугээр сарын 03-ны өдрийн байдлаар нийт 1495 нэгж талбарын газар, эд хөрөнгө өмчлөгч иргэдэд 285.7 тэрбум төгрөгийн нөхөх олговрын гүйлгээ хийсэн.<br>Нийслэлийн Засаг даргын 3 захирамжийн төсөлд 42 нэгж талбарт 7.9 тэрбум төгрөг олгохоор хянагдаж байгаа бөгөөд 16 иргэнтэй Газар чөлөөлөх гэрээ байгуулсан боловч нөхөх олговрын хөрөнгө дууссан. Өссөн дүнгээр нийт 1633 нэгж талбартай гэрээ байгуулаад байна. | |
| 3.1.8.3 | Хаягдал усыг гүн цэвэршүүлэн дулаан, цахилгаан станцуудад техникийн усны зориулалтаар дахин ашиглах төслийн хүрээнд газар чөлөөлөлтийг зохион байгуулах | 3,000,0 Гадаадын зээл, тусламж (ММСС) | Газар чөлөөлөх нэгж талбар, тоо | 16 | 16 | Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/220 дугаар захирамжаар тус төслийн нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх “Хэрэгжүүлэгч байгууллагын гэрээ”-нд гарын үсэг зурах эрхийг олгосон. Хаягдал усыг гүн цэвэршүүлэн дулаан, цахилгаан станцуудад техникийн усны зориулалтаар дахин ашиглах төслийн шугам сүлжээний нөлөөлөлд өртсөн 32 нэгж талбарыг 2,9 тэрбум төгрөгийн нөхөх олговортойгоор чөлөөлсөн бөгөөд нөхөх олговрыг Мянганы сорилтын сангаас олгож газар чөлөөлөлтийн ажил бүрэн дууссан. | 100% |
| 3.1.9 | Салбарын архивын албан мэдээллийг бүрдүүлэн, сан | Үйл ажиллагаа | 30 ажил Баянзүрх дүүргийн нэгж талбарын | 2021 онд 65 ажлын бүрдлийг шалгаж акт | Төрийн архивт хүлээлгэн өгөхөөр ирүүлсэн 30 ажлыг шалгаж акт үйлдэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөмрөг үүсгэх, архивлах | | хувийн хэрэг | үйлдэн хүлээн авсан. Налайх дүүргийн нэгж талбарын хувийн хэргийн баримтыг хүлээн авсан. | хүлээн авна. Баянзүрх дүүргийн 35543 нэгж талбарын хувийн хэргийн 678 хадгаламжийн нэгжийн баримтыг төрийн архивт хүлээн авсан байна. | | |
| 3.1.9.1 | Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон архивд ирүүлсэн ажлыг хүлээн авах | Үйл ажиллагаа | Үүсгэсэн хадгаламжийн нэгжийн тоо | 2023 онд 5575 ажлын бүрдлийг шалгаж акт үйлдэн хүлээн авсан. | **Эхний хагас жилд:** . Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон архивд ирүүлсэн ажлыг хүлээн авч, данс бүртгэл үүсгэсэн байна.<br>**Жилийн эцэст:** Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон гэрээт ажлын хүрээнд хийж төрийн архивт ирүүлсэн ажлыг хүлээн авч, данс бүртгэл үүсгэсэн байна.<br>Архивд хадгалагдаж байгаа баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалт, өөрчлөлт, хөдөлгөөний мэдээлэл болон нэгж | Архивын ажлын төлөвлөгөөнд 13 арга хэмжээ тусган боловсруулж, 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр батлуулсан.<br>Архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа 108595 хадгаламжийн нэгж болон хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 оны нийт 987 баримтыг шинээр бүртгэлжүүлэн тоон мэдээг Нийслэлийн Архивын газарт 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдөр файлаар хүлээлгэн өгсөн.<br><br>Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны нэгжүүд архивд баримт хүлээлгэн өгөх хуваарь гарган, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2022 оны 1651, 2023 оны 957 баримт, албан бичиг, нэгж талбарын хувийн хэрэг, барьцаанд бүртгүүлэх, чөлөөлөх, хаяг оруулах байшин оруулах зэрэг 2608 баримтын нийт 5216 хадгаламжийн нэгжийн данс бүртгэл үүсгэн архивын сан хөмрөгт хүлээн авч бүртгэлжүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | талбарын хувийн хэргийн судалгааг загварын дагуу гаргаж, 12 дугаар сарын 10-ны дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | | |
| 3.1.14 | Худалдан авах ажлыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих | Үйл ажиллагаа | 1 Төлөвлөгөө, 2 тайлан, ажил үйлчилгээний тоо | Ерөнхий төлөвлөгөөнд туссан 12 ажил, үйлчилгээний худалдан авалтыг хийж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, гэрээт ажлыг хүлээн авсан. | Ерөнхий төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөн туссан ажлууд бүрэн хэрэгжиж, тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | | |
| 3.1.14.1 | Байгууллагын 2024 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулах, тайлагнах | Үйл ажиллагаа | 1 Төлөвлөгөө, 2 тайлан | 2023 оны худалдан авах ерөнхий төлөвлөгөө батлуулсан. | Худалдан авах ерөнхий төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулсан байна. Тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр батлуулж, тайлан мэдээг тухай бүр НЗДТГ-т хүргүүлсэн.<br>2024 онд 10 төрлийн бараа, ажил, үйлчилгээг 1,551.0 сая төгрөгөөр худалдан авахаар төсөв батлуулсан бөгөөд 1 худалдан авах ажиллагааг шууд худалдан авалтаар, 7 төрлийн 1,071.0 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер зарлаж тендер шалгарсан байгууллагуудтай гэрээ байгуулан ажилласан.<br>2 худалдан авах ажиллагааны хүрээнд www.tender.gov.mn цахим тендер | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгаруулалтын системээр зарласан болович оролцогч санал ирүүлээгүй. | |

**ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | Төрийн албаны тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тухай бүр | - | | | |
| 4.1.1.1 | Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тухай бүр | - | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байна. | -ЗГ-ын 2024 оны 128 тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон тул албаны даргын 2024 оны Б/101 дүгээр тушаалаар төрийн захиргааны 183 албан хаагчийн, Б/102 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний 37 албан хаагчийн, Б/106 дугаар тушаалаар нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд ажиллаж байгаа 10 албан хаагчийн цалин, нэмэгдлийг тус тус шинэчлэн батлуулав.<br>-Төрийн албаны тухай хууль, ЗГ-ын 2024 оны 82 дугаар тогтоолын дагуу албаны даргын 2024 оны Б/103 дугаар тушаалаар нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны болон үйлчилгээний 20 албан хаагчид орон нутгийн нэмэгдэл, ЗГ-ын 2024 оны 83 дугаар тогтоолын дагуу албаны даргын 2024 оны Б/210 дугаар тушаалаар Багануур, Багахангай, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны 7 албан хаагчид 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгосон.<br>-Төрийн үйлчилгээний албан хаагчийн 2024 оны улирлын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, албаны даргын 2024 оны Б/230, Б/312 дугаар тушаалаар давхардсан тоогоор 65 албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгосон.<br>-Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 12 дугаар тогтоолын дагуу улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоосны дагуу 10 гэрээт ажилтны хөлсийг 2024 оны Б/24 дүгээр тушаалаар шинэчлэн батлуулсан.<br>-“Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгоход тавигдах шалгуур үзүүлэлт”-ийн шалгуур хангасан 1 албан хаагчид албаны даргын 2024 оны А/81 дүгээр тушаалаар архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэшлийн ахлах зэрэг олгосон.<br>-ЗГ-ын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.2, 8.4 дэх заалтад заасны дагуу албан хаагчийн ажилдаа ирэх, явах унааны зардлыг албаны даргын 2023 оны А/93 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж, унааны зардлыг өдрийн 1000 төгрөг, хоолны хөнгөлөлтийг нэмэгдүүлж өдрийн 24000 төгрөгөөр тооцон сар тутам олгож байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -ТАЗ-ийн нийслэл дэх салбар зөвлөлөөс ирүүлсэн 2024 оны 15/07 дугаар албан бичгийн дагуу 24 албан хаагчид төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвийг шинээр, 63 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгох саналыг 2024 оны 01-01/817 дугаар албан бичгээр хүргүүлж, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/369 дүгээр захирамжаар нийт 87 албан хаагчид зэрэг дэвийг олгосон. | |
| 4.1.1.2 | Сул болон түр эзгүй байгаа орон тоог Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сул болон эзгүй орон тоо | - | - Сул болон түр эзгүй байгаа орон тоо гарсан тохиолдолд “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна | Тус албанаас 2023 оны 01-04/5914, 2024 оны 01-04/202, 01-01/5637, 01-01/8192 дугаар албан бичгээр төрийн захиргааны албан тушаалын 27 сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлөөс тус албаны 4 удирдах, 14 гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд зарлуулж, тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо авсан иргэнийг албан тушаалын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай 18 тогтоол ирүүлсний дагуу 18 иргэнийг албан тушаалд томилсон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Тухайн албан тушаалд нэр дэвшигчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулах, дүгнэлтийг үндэслэн шийдвэрийн төсөл боловсруулан албажуулах ажлыг зохион байгуулсан байна. | | |
| 4.1.1.3 | “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөсөн арга хэмжээний тоо | “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр” /2021-2025/-ыг баталсан. | “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж, биелэлтийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах 2024 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>-Эрүүл мэндийн шалтгаантай 11 албан хаагчид цалинтай чөлөө, гэр бүлийн гишүүн нь эрүүл мэндийн шалтгаантай 12 албан хаагчид цалинтай чөлөө, ар гэрийн шалтгаантай 12 албан хаагчид цалингүй чөлөө, сургалтад хамрагдсан 49 албан хаагчид цалинтай чөлөө тус тус олгож, хөгжлийн бэрхшээлтэй 2 албан хаагчийн ажлын цагаас хорогдуулж, 1 албан хаагчид хүүхэд хөхүүлэх нэмэлт цаг, 5 албан хаагчийн ажлын цагийн хуваарьт өөрчлөлт оруулж тус тус шийдвэрлэсэн.<br>-Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 10.1.3 дахь заалтад заасны дагуу албан хаагчийн ахуй амьдрал, ар гэрт гачигдал тохиолдсон 14 албан хаагчид 6,8 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 17 албан хаагчид албаны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даргын тушаалаар цалинтай чөлөө олгосон.<br>-Хөдөлмөрийн тухай хуулийн 137.5 дахь хэсэгт заасны дагуу гэр бүлд нь хүүхэд мэндэлсэн 7 албан хаагчид цалинтай 10 хоногийн чөлөө олгож, дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговрыг олгосон.<br>-Шинээр гэр бүл болж, хурим хийсэн 2 албан хаагчид албаны даргын тушаалаар цалинтай чөлөө олгосон.<br>-Өндөр насны тэтгэвэрт гарах насанд хүрсэн 1 албан хаагчид 36 сарын цалинтай тэнцэх 32,1 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.<br>-Албаны даргын 2024 оны А/145 дугаар тушаалаар төрийн албан хаагчдад өвлийн улирлын бэлтгэлээ хангахад нь зориулж галлагаатай гэр байшинд амьдардаг 25 албан хаагчид нөхөх төлбөр олгосон.<br>-Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн үнэлгээний дагуу 1 дүгээр улиралд 189 албан хаагчдад 76,9 сая төгрөг, хагас жилээр 194 албан хаагчид 116,3 сая төгрөг, 3 дугаар улиралд 202 албан хаагчид 112,7 сая төгрөгийн урамшуулал олгосон. | |
| 4.1.1.4 | Салбарын хэмжээнд “Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | Салбарын хэмжээнд Жэндерийн талаарх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. | Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаН биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган | Албаны “Жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаН ажиллаж байна.<br>Албаны “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 11.3 дахь хэсэгт: Албан хаагч нь ялгаварлан гадуурхагдсан, аливаа хэлбэрээр дарамт, хүчирхийлэлд өртсөн гэж үзвэл Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэнд өөрт | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан байна. | байгаа баримт, мэдээллийн хамт гомдол гаргана. 11.4 дэх хэсэгт: Энэхүү журмын 11.3 дахь хэсэгт заасан гомдлыг хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн шалгаж, ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ. 12.7 дахь хэсэгт: Албан хаагч нь албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхахыг хориглоно. 12.8 дахь хэсэгт Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 4.1.6, 4.1.7 дахь заалтад заасны дагуу албан хаагчийг ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхах, аливаа хэлбэрээр хүчирхийлэх, дарамтлахыг хориглоно гэсэн заалтуудыг тусган, нийт албан хаагчдад мэдээллийн цагаар, шинээр томилогдсон албан хаагчдад шинэ ажилтны сургалтад тухай бүр танилцуулсан. Ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар санал гомдол 2024 онд ирээгүй байна.<br>Батлагдсан төлөвлөгөөний дагуу байгууллагын албан хаагчдын нас, хүйсийн тэнцвэртэй байдлын судалгааг гаргаж, НЗДТГ-т 2024 оны 01-01/3960 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хороо, Нэгдсэн Үндэсний байгууллагын хүн амын дэмжлэгтэйгээр үндэсний хэмжээнд зарласан “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ” 1 сарын аянд нэгдэн зурагт хуудсыг хийлгэж, цахим хуудас, пэйж хуудсуудад байршуулж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сурталчлан, албан хаагчдад жендэрийн эрх тэгш байдлын талаар сургалтыг зохион байгуулж, тайланг НЗДТГ-т 2024 оны 0-01/1873 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>НЗДТГ-аас зохион байгуулж байгаа "Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг 14 хоногийн аян"-д нэгдэн, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. | |
| 4.1.1.5 | “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо” цахим системд мэдээллийг оруулах, тухай бүр шинэчлэх | Үйл ажиллагаа | Албан хаагчийн тоо | 245 | “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо” цахим системд мэдээллийг оруулах, тухай бүр шинэчилсэн байна. | Шинээр болон шилжин, сэлгэн томилогдсон, чөлөөлөгдсөн, түр чөлөөлөгдсөн, цалин, нэмэгдэл шинэчлэн баталсан, нийгмийн даатгалын код өөрчлөгдсөн 268 албан хаагчийн мэдээллийг давхардсан тоогоор 1500 гаруй нэмэлт өөрчлөлтийг “Хүний нөөцийн нэгдсэн систем”-д бүртгэсэн.<br>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын нэгдсэн удирдлагын системд шинээр томилогдсон, чөлөөлөгдсөн, шилжсэн, сэлгэн томилогдсон албан хаагчдыг мэдээллийг бүртгэн давхардсан тоогоор 380 гаруй өөрчлөлтийг хийж бүртгэсэн. | 100% |
| 4.1.1.6 | Хүний нөөцийн тоо бүртгэл, бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээ, судалгааг ГЗБГЗЗЕГ-т ирүүлэх | Үйл ажиллагаа | Мэдээ, судалгааны тоо | - | Хүний нөөцийн чиглэлээрх салбарын албан хаагчдын бүх төрлийн нэгдсэн судалгаа, мэдээллийг цуглуулж, нэгтгэн цаг хугацаанд нь ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Хүний нөөцийн тоо бүртгэл, бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээ, судалгааг ГЗБГЗЗЕГ болон НЗДТГ-т 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдөр хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.2 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа | 12 удаа | - | Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг заасан хугацаанд оруулсан байна. | | |
| 4.1.2.1 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа | Мэдээллийн тоо | - | Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө, тайлан, санхүү, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан орон тооны мэдээлэл, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг сар бүр оруулж | 2024 оны байдлаар нийт 171 мэдээг www.shilendans.gov.mn сайтад мэдээллэхээс 2024 оны байдлаар 150 мэдээг ил тод, нээлттэй тайлагнасан. Зарлагын 340,4 тэрбум төгрөгийн дүнтэй 2039 гүйлгээ, орлогын 347,1 тэрбум төгрөгийн дүнтэй 228 гүйлгээний мэдээлэл оруулсан бөгөөд мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь байршуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баталгаажуулсан байна. | | |
| 4.1.3 | Авлигын тухай болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө, 3 тайлан, | - | Төлөвлөө болон тайланг холбогдох байгууллагад хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна. | | |
| 4.1.3.1 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнах | Үйл ажиллагаа | Тайлангийн тоо | 2022 онд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн. | Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Газрын даргаар батлуулсан байна Хэрэгжилтийг хангаж, тайланг ГЗБГЗЗЕГ-т хагас, бүтэн жилээр хүргүүлсэн байна. | Албаны авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд тусгах саналыг нийт албан хаагчдаас авч, 5 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, албаны дарга Г.Мөнхбаатар 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн албаны “Мэдээллийн цаг”-аар төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, гүйцэтгэх нэгж болон хүрэх үр дүнг 219 албан хаагчид танилцуулсан.<br>Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг НЗДТГ-т 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 01-01/4071, 09 дүгээр сарын 13-ны өдрийн 01-01/6202 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. | 100% |
| 4.1.3.2 | Албан тушаалтнуудын 2023 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үйл ажиллагааг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Мэдүүлэг гаргагчийн тоо | 2022 оны тайланг хугацаанд нь хүргүүлсэн. | Албан тушаалтнуудын 2023 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө | Төрийн захиргааны 191 албан хаагчийн 2023 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө хугацаанд нь авч мэдээ тайланг НЗДТГ-т хүргүүлсэн.<br>Шинээр томилогдсон болон шилжин, сэлгэн ажилласан 76 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлэг, 9 албан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | авах ажлыг зохион байгуулсан байна. | хаагчийн их хэмжээний өөрчлөлтийг хүлээн авч баталгаажуулсан. | |
| 4.1.3.3 | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хүлээн авч бүртгэх | Үйл ажиллагаа | Мэдүүлгийн тоо | - | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг албан хаагчдаас хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | Тайлант хугацаанд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай 3040 мэдэгдэл, тайлбарыг хүлээн авч, Авлигатай тэмцэх газрын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын бүрдүүлэлтийн системд бүртгэсэн. | 100% |
| 4.1.3.4 | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Мэдүүлгийн тоо | - | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авилгатай тэмцэх газарт хүргүүлсэн байна. | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 110 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулж, албан хаагчдыг албан тушаалд томилсон. | 100% |
| 4.1.4 | Тогтоол шийдвэрийн, биелэлтэд хяналт тавих | Үйл ажиллагаа | Тогтоол шийдвэрийн бүртгэл хөтөлсөн байдал | 78 тогтоол шийдвэрийн биелэлтийг журамд заасан хугацаанд тайлагнасан. | Бүртгэлд авсан тогтоол шийдвэрийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журамд заасан хугацаанд холбогдох газарт | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тайлагнасан байна. | | |
| 4.1.4.1 | Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, Барилга, хот байгуулалтын яам, ГЗБГЗЗЕГ болон бусад байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах | Үйл ажиллагаа | Тогтоол, шийдвэрийн тоо | - | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг авч хүлээн бүртгэлжүүлэн, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр холбогдох газарт тайлагнасан байна. | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, НЗД-ын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу бодлогын баримт бичгийн байгууллагад хамаарах заалтуудын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын тамгын газарт сар, улирал, жилийн эцсээр тухай бүр хүргүүлэн ажилласан.<br>-Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 3 арга хэмжээний биелэлтийн дундаж 100 хувьтай;<br>-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 14 арга хэмжээний биелэлтийн дундаж 92.1 хувьтай;<br>-Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд туссан 10 арга хэмжээний биелэлтийн дундаж 96.6 хувьтай;<br>-Нийслэлийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд туссан 12 арга хэмжээний биелэлтийн дундаж 94.2 хувьтай тус тус хэрэгжсэн байна.<br>-Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 3 заалт, УИХ-ын 2 тогтоолын 3 заалт, УИХ-ын байнгын хорооны 1 тогтоолын 1 заалт, Засгийн газрын 9 тогтоолын 15 заалт, Засгийн газрын хуралдааны 13 тэмдэглэлийн 16 заалт, Засгийн газрын 1 албан даалгаврын 1 заалтыг тус тус хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан 2024 оны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | биелэлтийн дундаж 92,7 хувьтайгаар тайлагнан ажилласан.<br>-ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны 2 тушаал ирснийг хяналтад авч, хэрэгжилтийг хангаж ажилласан. | |
| 4.1.5 | Байгууллагын хэмжээнд эрх зүйн баримт бичиг боловсруулалт, хэрэгжилтэд хяналт тавих | Үйл ажиллагаа | 380 тушаал, 280 гэрээ, 1 журам, 1 эмхэтгэл | - | Тушаал болон гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж, дугаар олгож бүртгэсэн байна. Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт орж батлагдсан байна. Эмхэтгэл бэлэн болсон байна. | | |
| 4.1.5.1 | Албаны даргын тушаалын үндэслэлийг хянаж, бүртгэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тушаалын төслийн тоо | - | Албаны даргын тушаалын төслийг боловсруулж, бүртгэл хөтөлж, тушаалын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, хэрэгжилтийн тайланг гаргасан байна. | Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр А тушаал 150, хүний нөөцийн чиглэлээр Б тушаал 367 нийт 517 тушаалд холбогдох нэгжүүдээс санал авч, хууль зүйн үндэслэлийг хянаж, баталгаажуулсан. | 100% |
| 4.1.5.2 | Байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, албажуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Шинэчлэн боловсруулсан дүрэм, журмын тоо | - | Салбарын хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмыг шинэчлэн | Албаны хэмжээнд нийтээр дагаж мөрдөж байгаа 17 дүрэм, журмыг Захиргааны ерөнхий хуульд нийцсэн эсэхийг шалгаж, дүн шинжилгээ хийж 2 журам хүчингүй болгох, 15 журам өөрчлөн найруулах төлөвлөгөө 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдөр батлуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулж, албажуулан, үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна. | Үүнээс 1 журмыг хүчингүй болгож, 5 журмыг шинэчлэн боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна. | |
| 4.1.6 | Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, дүгнэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2023 оны 98 дугаар тушаалаар батлагдсан загвар, аргачлал | Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор журам шинэчлэн батлагдсан. | Журманд заасан хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг тайлагнасан байна. | | |
| 4.1.6.1 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Үнэлгээний мөрөөр авсан арга хэмжээний тоо | 2023 онд албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг жилээр, гүйцэтгэлийн тайланг хагас, бүтэн жилээр гарган үнэлгээ, дүгнэлт өгч ажилласан. | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах ажлыг зохион байгуулж, биелэлтийг үнэлж, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. | Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны 99 албан хаагч, дүүргийн газар зохион байгуулалтын албаны 122 албан хаагч, шилжин, сэлгэн, шинээр томилогдсон 59 албан хаагч буюу нийт 280 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган, улирал тутам явцын ярилцлага хийж, хагас, бүтэн жилээр хугацаанд нь тайлагнасан.<br>Албаны даргын 2024 оны А/80 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний багаар хэлэлцүүлэн дүгнэж, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн үнэлгээний дагуу 1 дүгээр улиралд 189 албан хаагчдад 76,9 сая төгрөг, хагас жилээр 194 албан хаагчид 116,3 сая төгрөг, 3 дугаар улиралд 202 албан хаагчид 112,7 сая төгрөгийн урамшуулал олгосон.<br>Үнэлгээний багийг 2024 оны А/149 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулж, 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тайланг үнэлэх ажлыг зохион байгуулж байна. | |
| 4.1.7 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдалтын хувь | - | Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын эрхтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. | | |
| 4.1.7.1 | Дүүргийн Газар зохион байгуулалтын албадын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | Төлөвлөгөөний хэрэгжилт | - | Дүүргийн Газар зохион байгуулалтын албадын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг хэлэлцэж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.<br>Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулж, | Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх 2024 оны төлөвлөгөөнд төлөвлөгөөт болон, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын чиглэлээр 6, байгууллагын ажилтан, албан хаагчдын ажлын сахилга хариуцлагыг сайжруулах, байгууллагын соёл, дэг журмыг сахиулах чиглэлээр 7, дотоод ажлын чиглэлээр 5 арга хэмжээ буюу нийт 18 арга хэмжээг тусгаж батлуулсан бөгөөд хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан. Төлөвлөгөөнөөс бүрэн хэрэгжсэн 15, хэрэгжих шатандаа 3 арга хэмжээ байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 95 хувьтай байна.<br>2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр байгууллагын сургалт, мэдээллийн цагаар Төрийн албаны тухай хууль | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үр дүнг хурлаар хэлэлцүүлж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. | болон төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аливаа ёс зүйн болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар сургалт зохион байгуулсан.<br>Мөн дүүргийн Газар зохион байгуулалтын албадын Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн албан хаагчдад байгууллагын ажилтан, албан хаагчдын ажлын сахилга хариуцлагыг сайжруулах, байгууллагын соёл, дэг журмыг сахиулах чиглэлээр сургалт зохион байгуулсан.<br>Дотоод хяналт, шалгалтын явцад албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангаагүй, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй буюу албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, албан бичиг, өргөдөл, гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн, шийдвэрлэлтийн явцад зөрчил гаргасан, ажлын цагийг хангалтгүй ашигласан, иргэдээс ирсэн гомдлыг шийдвэрлэх хүрээнд давхардсан тоогоор нийт 72 албан хаагчид Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн дагуу сонсох ажиллагаа явуулж, 10 албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1-48.1.3 дахь заалтад заасан сахилгын шийтгэл ногдуулж, 1 албан хаагчийг ажлаас чөлөөлж, зөрчил гаргасан 3 албан хаагч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Албаны даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс 06 дугаар сарын 04-ний өдрүүдэд 9 дүүргийн 11 газар зохион байгуулалтын албаны үйл ажиллагаанд бүрэн хэмжээний төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийж, үр дүнг удирдлагын шуурхай хуралд танилцуулан Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж хариу өгөх болон дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн зарим үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр зөвлөмж хүргүүлсэн.<br>Дүүргийн Газар зохион байгуулалтын албад нь Газрын кадастрын цахим системд бүртгэсэн газартай холбоотой иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтийг хуулийн хугацаанд хэрхэн шийдвэрлэж, хариу өгч байгаа эсэх, газар эзэмших, ашиглах гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж байгаа эсэх болон гэрээ дүгнэсэн актыг нэгж талбарын хувийн хэрэгт хавсаргасан байдал зэрэгт гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу Налайх ДГЗБА-д бүрэн гүйцэтгэж дууссан бөгөөд Сонгинохайрхан ДГЗБА-д хийгдэж байна.<br>Иргэд олон нийтийн зүгээс ирж буй өргөдөл, гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр зөвлөмж, чиглэл боловсруулан 2024 оны 01-01/1551, 01-01/2090, 01-01/4142, 01- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 01/4358 дугаар албан бичгээр тус тус холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>Мөн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол маргааныг нотлох баримттайгаар эцэслэн шийдвэрлэх зорилгоор 9 дүүргийн 11 Газар зохион байгуулалтын албанд дуу, дүрсний өндөр нарийвчлалтай дүрс бичлэгийн камер байршуулсан ба ингэснээр албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой өргөдөл, гомдлыг нотлох баримттайгаар эцэслэн шийдвэрлэх боломж бүрдсэн төдийгүй албан хаагчдын ажлын цаг ашиглалтад байнгын хяналт тавин ажиллаж байна. | |
| 4.1.8 | Хурал, зөвлөгөөн зохион байгуулах | Үйл ажиллагаа | | 2021 онд 5 хурал, 3 зөвлөгөөн зохион байгуулагдсан. | Хурал, зөвлөгөөн, форумыг хугацаанд нь зохион байгуулж, биелэлтийг тайлагнасан байна. | | |
| 4.1.8.1 | Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд зарлагдсан “Бүтээлч ажил”-ыг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | Бүтээлч ажлын тоо, Хэрэгжилтийн байдал | - | Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн арга хэмжээний төлөвлөгөө болон зарлагдсан | Монгол Улсад газрын харилцааны салбар үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд салбарын хэмжээнд хэрэгжүүлэх 70 бүтээлч ажлын саналыг 2024.01.22-ны өдрийн 01-01/293 дугаар албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.<br>Төлөвлөгөөнд тус албатай хамааралтай 41 үйл ажиллагааг албаны шуурхай хурал олон нийт албан хаагчдад мэдээллийн цагаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүтээлч ажлын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. | танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Албанаас хариуцан хэрэгжүүлэх "Газрын харилцааны ажилтны өдрийн нэрэмжит Шилжин явах цомын төлөөх Улсын аварга шалгаруулах спортын зургаан төрөлт тэмцээн"-ийг 2024 оны 04 дүгээр сарын 25-наас 27-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан. Тэмцээнд 12 багийн 400 гаруй тамирчид оролцсон. | |
| 4.1.9 | Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолоор Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр батлагдсан. | Хөтөлбөрийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна. | | |
| 4.1.9.1 | Батлагдсан "Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сургалтын тоо | 64 | "Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө"-г боловсруулан Албаны даргаар батлуулж, хэрэгжүүлж ажилласан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан байна. | Байгууллагын сургалтын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр батлуулж, хууль эрх зүй, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, архив, албан хэрэг хөтлөлт, мэргэжлийн чиглэлийн нийт 54 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 2520 албан хаагчийг хамруулсан. Төлөвлөгөөний дагуу Төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн сургалтад 4 албан хаагч, төрийн захиргааны ахлах түшмэлийн сургалтад 6 удирдах болон гүйцэтгэх албан хаагч, төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад 3 албан хаагчийг тус тус хамруулсан. | 100% |
| 4.1.9.2 | Салбарын хууль тогтоомжийн хүрээнд Нийслэл, | Үйл ажиллагаа | Сургалтад хамрагдсан албан | - | Газрын тухай хуульд орсон нэмэлт | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас зохион байгуулсан "Хариуцлагатай газрын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дүүргийн газар зохион байгуулалтын албаны албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангаж, сургалт зохион байгуулах | | хаагчдын тоо | | өөрчлөлтийн талаар болон салбарын хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна. | харилцаа" аяны хүрээнд нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албад 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 06 дугаар сарын 03-ны өдрүүдэд иргэд, олон нийтэд салбарын хууль тогтоомжийг сурталчлах, салбарын хууль тогтоомжийн хүрээнд илэрч буй нийтлэг зөрчил, анхаарах асуудал, иргэн хуулийн этгээдийн эрх үүрэг, газрын зөрчил, маргаан, түүнээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгч, салбарын үйл ажиллагааг олон нийтэд таниулах сурталчлах ажлыг хамтран зохион байгуулсан.<br>2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн албаны мэдээллийн цагаар "Нийслэлийн газрын эрхийн маргаан таслах зөвлөлийн ажиллах журам"-ын танилцуулга бэлтгэн нийт албан хаагчдад танилцуулсан.<br>2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны нийт албан хаагч нарт зориулсан мэдээллийн цагаар:<br>-"Үндсэн хуулийн үзэл баримтлал, түүнд орсон нэмэлт өөрчлөлт" сэдвээр,<br>Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Ч.Батзориг, Ц.Хулан, Б.Хүслэн нар, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар С.Баярцэцэг, Н.Бямбадорж нарыг урьж оролцуулан, нийт албан хаагчдад "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай", "Авлига, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, түүнд оногдуулах ял шийтгэл", "Газрын салбар дахь авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх нь" сэдвээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. | |
| 4.1.10 | Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй ил тод, шуурхай байх нөхцөл боломжийг бүрдүүлэх | Үйл ажиллагаа | - | - | Байгууллагын үйл ажиллагааны мэдээ олон нийтэд шуурхай хүрдэг болсон байна. | | |
| 4.1.10.1 | Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээгээр сурталчилсан. | Салбарын үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээг сурталчлан таниулж, нийтэд хүргэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын албаны ажлын байр болон нийслэлийн үйлчилгээний нэгдсэн 3 төвд нийт 22 цахим үйлчилгээний киоск төхөөрөмжийг байршуулан, тэдгээрээр дамжуулан газрын харилцааны үйлчилгээг сурталчлах ажлыг үзүүлж байна. Мөн киоск төхөөрөмжөөс хэрхэн үйлчилгээ авах талаар гарын авлагыг шинэчлэн боловсруулан байршуулсан.<br><br>Албаны үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчилах, танилцуулах арга хэмжээ:<br>-14 богино хэмжээний видио зохиомж, 30 гаруй төрлийн постер хийгдэж, нэгжийн дарга нар Eagle, NTV, MNB, Тэнгэр телевиз, TV5 телевизийн Live сувгуудад давхардсан тоогоор 10 гаруй удаагийн ярилцлага өгсөн байна.<br>-Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд албаны үйл ажиллагааг танилцуулах, үйлчилгээ авах боломжийг бий болгох ажлын хүрээнд нийт 5 видео контендод дүрсний орчуулга | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийлгэхээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газартай хамтран ажиллаж байна.<br>-Албаны цахим хуудсыг шинэчлэн хөгжүүлэх ажил Анир И Эл Эс ХХК-тай Ажил гүйцэтгэх гэрээний дагуу www.land.ub.gov.mn цахим хуудас хийж дууссан. Уг ажлаар иргэд албаны цахим хуудаснаас өөрт хэрэгтэй мэдээллийг олж авахад амар ойлгомжтой байдлаар хөгжүүлэлт хийгдсэн ба нийт нэгжүүдээс холбогдох мэдээллийг шинэчлэн оруулж дууссан. | |
| 4.1.11 | Албан хэрэг хөтлөлтийн ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардал | Баримт бичиг | 2022 онд 3600 албан бичиг, 500 өргөдөл, гомдол хүлээн авсан. | Газарт ирсэн, явсан, өргөдөл гомдлыг “Байгууллагын удирдлагын цогц цахим систем”-д бүртгэлжүүлж, тайлан мэдээг гаргасан байна. | | |
| 4.1.11.1 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хариутай албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэж, тайлагнах | Үйл ажиллагаа | Ирүүлсэн албан бичгийн тоо, Явуулсан албан бичгийн тоо, Өргөдлийн тоо, Тайлангийн тоо | 2023 онд 7398 албан бичиг, 2293 өргөдөл, гомдол хүлээн авч, хариутай 7183 албан бичиг, 2199 өргөдөл, гомдол шийдвэрлэсэн. | - Байгууллагад ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг бүртгэж, холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байна.<br>-Байгууллагаас явуулж буй албан бичгийг бүртгэж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | Албаны хэмжээнд 8643 албан бичиг ирснээс 8383 албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, судалж байгаа 260 албан бичиг байна. Шийдвэрлэлтийн явцад зөрчил 95, хугацаа хэтрэлт 4, дундаж хугацаа 6 хоног 3 цаг байна.<br>Тоон гарын үсгээр нийт 8631 албан бичгийг баталгаажуулан, холбогдох иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад хүргүүлсэн.<br>Албаны хэмжээнд 2244 өргөдөл, гомдол ирснээс 2137 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, судалж байгаа 99 өргөдөл гомдол байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Хариутай албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийн мэдээ тайланг тухай бүр гаргаж, тайлагнасан байна.<br>- Өргөдөл, гомдлын мэдээг холбогдох байгууллагад улирал бүр тайлагнасан байна. | Шийдвэрлэлтийн явцад зөрчил 144, хугацаа хэтрэлт 2, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 12 хоног 8 цаг 25 минут, шийдвэрлэлтийн индекс 87.8% буюу A үнэлгээтэй байна.<br>Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг ГЗБГЗЗЕГ-т 21 удаа цахим шуудангаар хүргүүлсэн. | |
| 4.1.12 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа | Хадгаламжийн нэгж | Байгууллагын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2022 онд 358 хадгаламжийн нэгж үүсгэсэн. | Байгууллагын архивт баримт хүлээн авах, бүртгэх, нягтлан шалгалт хийх, тоо бүртгэл хөтлөх, тооллого явуулах, хадгалах, хамгаалах, ашиглуулах, данс бүртгэл хөтлөх, устгах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулсан байна. | | |
| 4.1.12.1 | Байгууллагын архивын албан мэдээллийг бүрдүүлэн, сан хөмрөг үүсгэх, архивлах | Үйл ажиллагаа | Хадгаламжийн нэгжийн тоо | 2023 онд Байгууллагын хөтөлж дууссан 2275 баримтыг Хөтлөх хэргийн нэрийн | 2024 оны байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, нөхөн бүрдүүлэх хуваарь гарган | Архивын ажлын төлөвлөгөөнд 13 арга хэмжээ тусган боловсруулж, 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр батлуулсан.<br>Архивын шаардлагатай тоног төхөөрөмж авах тендерийн ажлын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн архивласан. | батлуулсан байна.<br>2023 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт” болон нөхөн бүрдүүлэх хуваарийн дагуу хөтөлж дууссан баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивласан байна. | даалгавар болон үнэлгээний хороог 2024 оны А/72 дугаар тушаалаар байгуулж, 2024.07.09-ний өдөр тендер зарлаж сонгон шалгаруулалтаар шалгарсан компанитай гэрээ байгуулж, тендер сонгон шалгаруулалтаар 15, шууд гэрээгээр 8 нийт 23 архивын нягтаршуулсан шүүгээ авч, архивын хадгалалт хамгаалалтыг сайжрууллаа.<br>Архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа 108595 хадгаламжийн нэгж болон хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 оны нийт 987 баримтыг шинээр бүртгэлжүүлэн тоон мэдээг Нийслэлийн Архивын газарт 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүлээлгэн өгсөн. | |
| 4.1.12.2 | Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын дотоод зохион байгуулалтын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг зохион байгуулж, байгууллагын архивын чиг үүргийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө | - | **Эхний хагас жилд:**<br>Архивын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гаргаж, Улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангасан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлж, дүгнүүлсэн байна. | Архивын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гаргаж батлуулсан.<br><br>Улсын үзлэгт бэлтгэл ажлын хүрээнд архивын шаардлагатай тоног төхөөрөмж авах тендерийн ажлын даалгавар болон үнэлгээний хороог 2024 оны А/72 дугаар тушаалаар байгуулж, 2024.07.09-ний өдөр тендер зарлаж сонгон шалгаруулалтаар шалгарсан компанитай гэрээ байгуулж, тендер сонгон шалгаруулалтаар 15, шууд гэрээгээр 8 нийт 23 архивын нягтаршуулсан шүүгээ авч, архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулсан.<br><br>Архив, албан хэрэг хөтлөлтийн журам болон байгууллагын архивын нийтлэг журамд нийцүүлэн 2003-2021 оны 480 хадгаламжийн данс бүртгэлийн 34868 хадгаламжийн нэгжид нягтлан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгалт хийж, тооллого явуулан, эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийж архивын тэмдэг, шифр даран баталгаажуулсан. | |
| 4.2.1 | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх | - | Санхүүгийн хяналт шалгалтын дүн | Төсвийн тухай болон НББ-н тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг ил тод тайлагнаж ажилладаг. | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байна. | | |
| 4.2.1.1 | Төсвийн зардлыг бууруулж, хэмнэлт гаргаж ажиллах, бараа материалын болон үйлчилгээний орлогод хяналт тавьж орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-н тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан байна. Орлогын төлөвлөгөөг биелүүлж санхүү төсвийн зөрчилгүй ажилласан байна. | 2024 оны эхний 11 дүгээр сарын байдлаар улсын төсвийн санхүүжилт 6,985,267.700 төгрөг батлуулснаас 11 дүгээр сарын гүйцэтгэлээр 6,699,070.808 төгрөгийн урсгал зардал гарсан.<br>2024 оны батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулан, зардлын гүйцэтгэлд хяналт тавьж, өр авлагагүй ажиллан, цалингийн зардлаас 282,6 сая, бусад зардлаас 181,7 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан.<br>2024 онд 200,0 сая төгрөгийн төлөвлөгөө батлуулснаас 2024 оны эхний 11 дүгээр сарын байдлаар 87,2 сая төгрөгийн орлогын гүйцэтгэлтэй байна. | 100% |
| 4.2.1.2 | Байгууллагын санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж, аудитын дүгнэлт | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн | Санхүүгийн тайлан мэдээг хуулийн хугацаанд гаргаж, холбогдох | Нийслэл дэх төрийн аудитын газрын 2024 оны 180 дугаар албан бичгээр албаны 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын шалгалтын үр дүнд “Өөрчлөлтгүй дүгнэлт” буюу “Зөрчилгүй” дүгнэгдсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гаргуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх | | | төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | байгууллагуудад хүргүүлсэн байна. | Албаны санхүүгийн улирал бүрийн тайланг хуулийн хугацаанд 2024 оны 04 дүгээр сарын 15, 07 дугаар сарын 16, 10 дугаар сарын 15-ны өдөр e-report.mof.gov.mn цахим системээр ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан. | |
| 4.2.1.3 | Өр авлагыг цаг тухайд нь барагдуулж, өмнөх оныхоос бууруулж ажиллах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Үүссэн өр, авлагыг цаг тухайд нь барагдуулж тайлант жилд өр, авлагыг бууруулан ажилласан байна. | Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах, албан хаагчийн цалин хөлсийг цаг тухайд нь олгох, харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилт, үйлчилгээний төлбөр тооцоог цаг тухайд нь хийж өр, авлага үүсгэхгүй ажилласан.<br>2024 оны батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулан, зардлын гүйцэтгэлд хяналт тавьж, өр авлагагүй ажиллан, цалингийн зардлаас 282,6 сая, бусад зардлаас 181,7 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан. | 100% |
| 4.2.1.4 | Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж хагас, бүтэн жилээр тооллого зохион байгуулах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Үндсэн хөрөнгийн болон бараа материалын ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж ажилласан байна. | Албаны даргын 2024 оны А/84 дүгээр тушаалаар тооллогын комисс байгуулж, 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 25-ны өдрийн дотор хийж гүйцэтгэн, тооллогын үр дүнг Өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулсан. Тооллогын дагуу 2024 оны А/111 дүгээр тушаалаар 44 нэр төрлийн 34.9 сая төгрөгийн ашиглах боломжгүй бараа материалыг акталж данс бүртгэлээс хассан.<br>Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 1562 ширхэг 9,141,211,218.59 төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгө нь цаашид ашиглах боломжгүй, ашиглалтын хугацаа дууссан тул акталж данснаас хасах саналыг Нийслэлийн Өмчийн харилцааны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газарт 2024 оны 01-02/588 дугаар албан бичгээр хүргүүлж, тус газрын 2024 оны А/300 дугаар тушаалаар 475,1 сая төгрөгийн 382 нэр төрлийн эргэлтийн бус хөрөнгө, 33 нэр төрлийн 8,662,7 сая төгрөгийн биет бус хөрөнгийг зохих журмын дагуу актаалсан.<br>Тус албанд ашигладаггүй 2 ширхэг 113,907,775 төгрөгийн балансын үнэ бүхий тоног төхөөрөмжийг 2024 оны 01-02/3269 дүгээр албан бичгээр балансаас хасуулахаар ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн.<br>Албаны даргын 2024 оны А/154 дүгээр тушаалаар жилийн эцсийн тооллогын комисс байгуулан ажиллаж байна. | |
| 4.2.1.5 | Санхүү болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, татвар, НДШ-ийн тайлан, Шилэн дансанд оруулах мэдээллийг хууль журамд заасан хугацаанд оруулж мэдээ тайланг холбогдох газруудад хүргүүлсэн байна. | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Хуульд заасан хугацаанд мэдээ тайланг тайлагнаж ажилласан байна. Мэдээ тайлангийн хугацааг хоцроохгүй байх. | 2024 оны байдлаар нийт 171 мэдээг www.shilendans.gov.mn сайтад мэдээллэхээс 2024 оны байдлаар 150 мэдээг ил тод, нээлттэй тайлагнасан.<br>Зарлагын 340,4 тэрбум төгрөгийн дүнтэй 2039 гүйлгээ, орлогын 347,1 тэрбум төгрөгийн дүнтэй 228 гүйлгээний мэдээлэл оруулсан бөгөөд мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь байршуулсан. | 100% |

***Төлөвлөгөөг хянасан:*** ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА .................................... (А.ЭНХМАНЛАЙ)

*2024.06.15*

***Төлөвлөгөөг тайлагнасан:*** ***Төсвийн Шууд захирагч***

НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА ..................................... (Г.МӨНХБААТАР)

*2024.06.15*